

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ “Түмэн шувуут” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал

Огноо: 2026 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр Цаг: 14:00 -17:55

Хурлын хэлбэр: Биечлэн оролцох

Хурлын дарга: Ломбын Эрхэмбаяр

Хурлын нарийн бичгийн дарга: Дашцэрэнгийн Наранцэцэг

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн тоо: 148

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн саналын эрхтэй хувьцааны тоо: 164,244,737 ш

Хурлын ирц: 82,37%

Хурлын дарга Л.Эрхэмбаяр: Энэ удаагийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Туушин зочид буудлын Соёмбо танхимд зохион байгуулав. Мөн хуралд оролцохоор цахимаар бүртгүүлсэн хувьцаа эзэмшигчдийн гар утсанд 2026 оны 04-р сарын 24-ны өдрөөс эхлэн нэвтрэх код хаягийг санал өгөх кодын хамт илгээсэн болно. Бүртгэлийг www.hural.tumenshuvuut.mn хаягаар цахимаар бүртгэсэн.

Хурлын дарга хурлын дэг болон хурлаар хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж хурлаар хэлэлцэх асуудал нэг бүрийг хэлэлцсэний дараагаар санал асуух, санал хэлэх, шүүмж хэлэхээр шийдвэрлэв. Жил бүрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг өвөрмөц сонирхолтой, олон нийтэд мэдээлэл хүргэх үүднээс зочин илтгэгчдийг урьж оролцуулдаг бөгөөд энэ жилийн тухайд 4 илтгэгч оролцсон.

ХУРЛААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ

1 дэх асуудал: “Түмэн шувуут” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг батлах;

2 дахь асуудал: Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох

3 дахь асуудал: Төлөөлөн Удирдах Зөвлөлийн зардлын төсвийг батлах

ХЭЛЭЛЦСЭН ТУХАЙ

1 ДЭХ АСУУДАЛ:

1. Хэлэлцсэн нь:

Танилцуулсан нь: Гүйцэтгэх захирал Ж.Болд

“Түмэн шувуут” ХК-ийн Гүйцэтгэх захирал Ж.Болд 2025 онд хийж гүйцэтгэсэн ажлууд, оны онцлох үйл явдлууд, тухайн оны санхүүгийн тайлан болон цаашид хийхээр төлөвлөж байгаа зорилтуудынхаа тухай дэлгэрэнгүй мэдээллийг хувьцаа эзэмшигчиддээ танилцуулав. /тайланг хавсаргав./ Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай Төлөөлөн Удирдах Зөвлөл хурлаараа хэлэлцээд дүгнэлт гаргасан бөгөөд уг дүгнэлтийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Хараат бус гишүүн, Аудитын хорооны дарга Ц.Наран-Учрал нийт хувьцаа эзэмшигчдэд уншиж сонордуулав.

2. Дараах зүйлийг баталсан тухай шийдвэр:

1. “Түмэн шувуут” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг батлав.

3. Энэ асуудлаар санал хураасан дүн:

Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
------------	------------	------------

Нийт саналын эрхтэй хувьцаа	Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа	Нийт саналын эрхтэй хувьцаа	Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа	Нийт саналын эрхтэй хувьцаа	Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа
199,388,849	164,244,737	199,388,849	164,244,737	199,388,849	164,244,737
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
160,409,444	99,97%	101	0%	51,338	0,03%

Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 99,97% зөвшөөрөв.

2 ДАХЬ АСУУДАЛ: Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох

ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг танилцуулах видеог дэлгэцээр үзүүлэв. Танхимд хүрэлцэн ирсэн нэр дэвшигчдийн нэрсийг дуудан хувьцаа эзэмшигчдэд танилцуулав.

Танилцуулгын гол агуулга: Кумулятив аргаар ердийн болон хараат бус гишүүнийг сонгох зааварчилгааг хувьцаа эзэмшигчдэд танилцуулав. Мөн цахимаар хэрхэн саналаа өгөх зөвлөмжийг өгөв.

Дараах зүйлийг баталсан тухай шийдвэр:

1. “Түмэн шувуут” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр сонгов:

1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнээр:

1. Ломбо овогтой Эрхэмбаяр
2. Балай овогтой Тунгалаг
3. Жигжид овогтой Болд
4. Эрхэмбаяр овогтой Баяржаргал
5. Агипар овогтой Бакей
6. Мэдраа овогтой Болод

2. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнээр:

1. Цэдэв овогтой Наран-Учрал
2. Гочоо овогтой Мөнх-Эрдэнэ
3. Өлзийбаяр овогтой Оргил-Эрдэнэ

2. Хууль тогтоомж, компанийн дүрэм, компанийн засаглалын журмуудыг мөрдөж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нийт гишүүдэд үүрэг болгож ТУЗ-ийн бүрэлдэхүүний талаарх олон нийтэд мэдээлж, шинээр сонгогдсон гишүүдийн мэдээллийг Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргэхийг Гүйцэтгэх захирал (Ж.Болд)-д үүрэг болгов.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Д.Наранцэцэг/-д үүрэг болгов.

2. Энэ асуудлаар санал хураасан дүн:

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнд нэр дэвшигчдэд кумулятив аргаар өгсөн санал:

Овог нэр	Санал өгсөн эрх	Саналын хувь
Ломбо Эрхэмбаяр	161,159,779	11,16%
Балай Тунгалаг	160,405,658	11,11%
Жигжид Болд	160,526,290	11,12%

Эрхэмбаяр Баяржаргал	160,448,908	11,11%
Агипар Бакей	160,255,763	11,10%
Мэдраа Болод	160,291,347	11,10%

Үүнээс: Л.Эрхэмбаяр, Б.Тунгалаг, Ж.Болд, Б.Баяржаргал, А.Бакей, М.Болод нар сонгогдов.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд нэр дэвшигчдэд кумулятив аргаар өгсөн санал:

Овог нэр	Санал өгсөн эрх	Саналын хувь
Гочоо Мөнх-Эрдэнэ	160,445,029	11,11%
Цэдэв Наран-Учрал	160,267,790	11,10%
Өлзийбаяр Оргил-Эрдэнэ	160,347,383	11,10%

ТУЗ-ийн хараат бус гишүүнээр Ц.Наран-Учрал, Г.Мөнх-Эрдэнэ, Ө.Оргил-Эрдэнэ нар сонгогдов.

3 ДАХЬ АСУУДАЛ:

1. Хэлэлцсэн нь:

Танилцуулсан нь: Хурлын дарга Л.Эрхэмбаяр

Танилцуулгын гол агуулга: Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн цалин, урамшуулал, зардлын төсөвийг хэмжээг тогтоох тухай хэлэлцэв.

2. Дараах зүйлийг баталсан тухай шийдвэр

1. “Түмэн шувуут” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн цалин, урамшууллыг хавсралтаар танилцуулав. *(Хавсралтаар: Ердийн болон хараат бус гишүүдийн цалинг улирал бүрийн тогтсон хурал хийж тогтмол 1,500,000 төгрөгийн цалин, хуралд оролцсон байдлаар тооцож ТУЗ-ийн 1 удаагийн хуралд оролцоход гишүүн тус бүр 500,000 төгрөгийн цалин авахаар танилцуулав.)*

2. Түүнчлэн Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах зардлын санхүүжүүлэлтийг хийж ажиллахаар танилцуулав.

3. Энэ асуудлаар санал хураасан дүн:

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Нийт саналын эрхтэй хувьцаа	Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа	Нийт саналын эрхтэй хувьцаа	Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа	Нийт саналын эрхтэй хувьцаа	Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа
199,388,849	164,244,737	199,388,849	164,244,737	199,388,849	164,244,737
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
160,408,627	99,97%	339	0%	51,997	0,03%

Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 99,97% нь зөвшөөрч, 0% нь татгалзаж, 0,03% нь түдгэлзэв.

Мөн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд “Онч аудит” ХХК-ийн партнер Б.Уранбилэг оролцож, хөндлөнгийн аудитын дүгнэлтийг танилцуулсан бөгөөд компанийн зүгээс хувьцаа эзэмшигчдэд Ногдол ашиг хуваарилах тухай мэдээллийг хүргэхээс гадна зочин илтгэгч Ө.Оргил-Эрдэнэ: “Хөрөнгөө зөв удирдах нь зөв асуулт

асуухаас эхэлнэ.”, Х.Хатанбаатар “Бүтээлч сэтгэлгээ ба Суралцахуй”, М.Болод “Брэндийг хэрхэн бүтээх вэ?”, Ж.Болд: “Бид хэрхэн ажилладаг вэ?” сэдвүүдээр сонирхолтой илтгэлүүд тавьсан нь хувьцаа эзэмшигчдэд үр өгөөжтэй байж, илүү олон төрлийн мэдээлэл авах хүсэлтэй байгаагаа илэрхийлж байсан.

АСУУЛТ ХАРИУЛТ:

ТУСГАЙ ТЭМДЭГЛЭЛ:

Хувьцаа эзэмшигч: Тайлангаас харахад бэлэн мөнгөний үлдэгдэл өссөн шалтгаан юу вэ, дараа дараагийн хөрөнгө оруулалтанд зарцуулахгүй байсан уу?

Гүйцэтгэх захирал Ж.Болд: Зээл авсан 7 тэрбум төгрөгийг он дуусаад авсан. Тийм учраас бэлэн мөнгөний үлдэгдэл өндөртэй харагдаж байгаа. Эргэлтийн хөрөнгийн зориулалтаар авсан зээл учраас тэжээлийн түүхий эд, үр тариа, улаанбуудай худалдан авахад зарцуулагдсан.

Хувьцаа эзэмшигч: Ашгийн маржин өмнөх онтой харьцуулахад унасан байна. Унасан шалтгаан юу вэ? Дайнтай холбоотой өссөн тээврийн зардал өртөгт хэрхэн нөлөөлөх вэ? Тооцоолол байгаа юу? Борлуулалтын хэдэн хувь нь хөдөө орон нутгийн харилцагч байгаа вэ?

Гүйцэтгэх захирал Ж.Болд: Нийт борлуулалтын 95 хувь нь Улаанбаатар хотод хийгддэг. 3800 харилцагч байгаа. Том худалдан авагчдыг багцалсан байгаа. Задлавал бүх их тоо гарна. Өмнө бидэнд орон нутаг руу тэлэх шаардлага байдаггүй байсан. Одоо үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлсэн учир хөдөө орон нутаг руу нийлүүлэх шаардлага зүй ёсоор гарч ирсэн. Хөдөө орон нутаг руу сүлжээгээ нэмэгдүүлэхээр ажиллаж эхэлж байна. Дээрээс нь “Тотал дистрибьюшн”ХХК-тай хамтарч байна. Мөн хөдөө орон нутагт дахь манай үндэсний сүлжээнүүдтэй хамтраад тэвээрлэлтийн асуудлын тодорхой хэсгийг хариуцаад хөдөө орон нутагт байгаа өндөгний үнэ Улаанбаатарт байгаа өндөгний үнэтэй адилхан байгаа. Дайнтай холбоотой тээврийн зардал яаж өсөхийг хэлж мэдэхгүй байна. Урьдчилсан байдлаар тооцооллууд хийгээд явж байгаа. Тээврийн зардал шувууны аж ахуйн зардалд тийм өндөр зардал учруулж чадахгүй. 10-аас хэтрэхгүй хувийг үзүүлдэг учраас их нөөлөөлөхгүй. Тэжээлийн түүхий эд, улаанбуудай үлэмж хувийг эзэлдэг. Айхтар их өсөхгүй бол ашгийн маржинд нөлөөлөхгүй гэж бодож байна. Бид 2024.10 сараас хойш бүтээгдэхүүнийхээ үнийг огт өсгөөгүй. Зардал байнга өсөлттэй байгаа. Өмнөх онуудад зардал бага байсан тул жил ирэх тусам ашгийн маржин буураад явж байна. Дараа жил ашгийн маржинг 15 хувь дээр барихаар тооцоолсон байгаа.

ТУЗ-ийн дарга Л.Эрхэмбаяр: Бид 2024 оноос хойш үнэ нэмээгүй байгаа. Инфляци нэмэгдээд байгаа. Бүх түүхий эдийн үнэ өсч байгаа, тийм учраас ашгийн маржин буураад байгаа. Бид 2024 онд 14.6 тэрбум төгрөгийн ашигтай байсан бол 2025 онд 14.2 тэрбумын ашигтай ажилласан. 400 саяаар дутуу байгаа ч үйлдвэрлэл нь 40-оод саяар нэмэгдсэн. Тэрэн дээрээ л тогтож бариад байгаа юм. Цаашдаа үнэ нэмэхгүй бариад байвал ашгийн маржин улам л буурна. Масс үйлдвэрлэлээр л барьж байгаа. Ашгийн төлөө гэхээс илүү тогтвортой байдлын төлөө Монголчууд хийж чаддаг юм шүү гэдгийг харуулахын төлөө ажиллаад байгаа юм. ОХУ-аас 5 дахин илүү үнэтэй цахилгаан хэрэглэж байна. Евро-Азийн асуудал гарахад бид бүгдийг нь судалсан. ОХУ-д 1 квт-50-60 төг байна. Манайд 1 квт-290-310 төг байна. Бензин шатахуун манайхаас 40-45 хувь хямдхан байна. Тоног төхөөрөмжийн сэлбэг запас 40-100 хувь хямд байна. Тиймээс гарч байгаа өндөгний үйлдвэрлэл хямд гарахаас аргагүй.

Хувьцаа эзэмшигч: Менежментийн багт баяр хүргэе. Маш сайхан бүтээн байгуулалт хийсэн байна. Сүүлийн хэлэн жил “Түмэн шувуут” ХК-д хөрөнгө оруулалт хийгээд байгаа. Хөрөнгийн биржид тайлангаа оруулахдсаа санхүүгийн тайлангийн тодруулгыг оруулж байна уу. Мэдээлэл авмаар байдаг юм. Үндсэн тайлан л ордог. Импортын өндгөнд ямар бодлого баримтлах вэ? Үндсэн үйл ажиллагаанаас 3 тэрбум төгрөгийн мөнгөн орлого олсон байна. Аудитын тайлангаар гарахдаа 10 тэрбум төгрөгийн гэсэн байсан. Мөнгөн гүйлгээний тайланд цэвэр ашгаас нь залруулга хэлбэрээр гаргасан байсан. Орлогын тайланд 23 тэрбум төгрөгийн биологийн хөрөнгийн үнэ цэнийн өсөлт гэж бүртгэсэн байсан. Мөнгөн гүйлгээний тайланд оруулж өгөөгүй байсан. Энэ ямар учиртай юм бэ?

Ерөнхий нягтлан бодогч Н.Должинсүрэн: Санхүүгийн тайлангийн тодруулга нь аудитын тайлан гарч амжаагүй байсан. Одоо аудитын тайлан баталгаажилтаар ирсэн учраас нэмэлтээр оруулж өгөх байх. Биологийн хөрөнгийн тухайд стандартын дагуу бүртгэл байгаа юм. Биологийн хөрөнгөөс гарч байгаа бүтээгдэхүүнийг хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн гэж үзнэ гээд стандартын дагуу бүртгэл нь өөр байдаг.

Мөнгөн хөрөнгөд хамаарахгүй стандарт дээрээ зах зээлийн бодит үнэ цэнээс борлуулах үнэ цэнийг хасна гэсэн заалт байдаг тэрний дагуу бүртгэлээ хийсэн. Өртөгөө өсгөж бүртгээд буцаагаад тодруулга дээрээ оруулдаг юм.

Гүйцэтгэх захирал Ж.Болд: Бид Монголын хөрөнгийн биржийн стандартаар явж байгаа. Хөрөнгө оруулагч нарт оруулж байгаа мэдээллийг бид дутуу оруулаагүй. Монголын бүх хувьцаат компаниуд яг энэ стандартаар явж байгаа.

Аудитын партнер Б.Уранбилэг: Бодит үнэ цэнээс борлуулалтын зардлыг хассан дүнгээр тохируулга хийж байгаа. Цэвэр ашгаасаа тохируулгууд дээрээ мөнгөн бус тохируулсаны дараагаар үндсэн үйл ажиллагаанаас олох 24.9 тэрбум төгрөг, 30.5 тэрбум төгрөгийг биологийн хөрөнгөндөө зарцуулсан байгаа.

Хувьцаа эзэмшигч: Хувьцааны төвлөрөл хэт их, хэт гэр бүлийн, хаалттай шинжтэй байна. Иймд төвлөрлийг хэрхэн бууруулах вэ? Ямар бодол бодолтой байгаа вэ? Үндэсний том компани байж байж ногдол ашиг чинь бага байна. Танайх чинь мундаг компани шүү дээ. Хэдэн оноос өр төлбөргүй болж ногдол ашиг илүү өгөх вэ?

ТУЗ-ийн дарга Л.Эрхэмбаяр: Том бага гэдэг борлуулалтаас гадна бүтээн байгуулалт, янз янзын зүйлээс шалтгаалдаг. Манайхыг том гэж бодоод байдаг боловч борлуулалтаараа АПУ компаниас 8-10 дахин бага гэж бодож байна. Энэ хариултанд эдийн засгийн ухааны доктор А.Бакей гишүүн хамтраад 1 хариулт өгөөч.

Эдийн засгийн ухааны доктор А.Бакей: Манай компанийг их сайн хэлж байна. Том компани гэж. Та бидний хүлээлт байна. Манай “Түмэн шувуут” ХК бол дунд зэргийн компани. Нийтдээ бол их хүлээлттэй байдаг. Том компани гэж. Их ногдол ашиг тараана гэж та нартай адилхан төсөөлөлтэй байсан. ТУЗ-ийн гишүүн болоод дотор нь ороод жаргал зовлонг нь үзэхэд тийм биш юмаа. Гэхдээ муу гэсэн үг биш. Хамгийн гол нь маш мундаг компани байна гэж үзсэн. Сая танилцуулга дээр та нар сайн харсан. Орлого нь сүүлийн 5 жил 3 дахин, зарлага мөн адил 3 дахин нэмэгдсэн. Санхүүгийн өсөлтүүд нь тогтвортой, өсөлттэй шинжтэй байна. Гэхдээ Монголд бизнес эрхлэх ямар хэцүүг сайн мэдэж байгаа байх. Сая Эрхэмбаяр даргын хэлсэнээр хямд үнэтэй, чанаргүй, импортын өндөгтэй өрсөлдөх хэцүү, зээл авна гэдэг нь байр сууриа бататгахын тулд их хэмжээний зээлийг төрийн дэмжлэгт хамруулж байж аваад зах зээлд эзлэх байр сууриа бататгасан. Жилийн өмнө зах зээлд эзлэх өндөгний 25 хувийг эзэлж байсан харин одоо 45 хувийг

шахуу эзэмшиж байна. Энэ нь өөрөөр хэлбэл зээл авч урд хормойгоороо хойд хормойгоо нөхсөний үр дүнд хүрч байгаа амжилт юм. Урт хугацааны үр өгөөжийг дээшлүүлэхийн төлөө маш сайн ажиллаж байна. Та бүхэн нэгэнт хөрөнгө оруулсан хүмүүс жаахан тэвчээртэй байвал гарцаагүй тогтвортой өснө гэдгийг хэлье. Яваандаа томорно.

ТУЗ-ийн дарга Л.Эрхэмбаяр: Хувьцааны төвлөрөл их, хаалттай шинжтэй байгаа гэдэг дээр үнэн гэж хэлье. Би манай эхнэр, охин нийлээд 75 орчим хувь байгаа. ТУЗ-ийн даргын хувьд биш хувь хүний хувьд хариулья. Надад бодол байна. Би хувьцаанаасаа зармаар байна. Би хэзээ ч 360 төгрөгөөр зарахгүй. Энд оруулсан үнэ цэнэ, зах зээлд миний сонирхол одоохондоо нийлж өгөхгүй байна. Би дор хаяж 700 төгрөгөөр зарна. Тэр хэзээг мэдэхгүй байна. Тэрнийг хурдлуулахын төлөө л бид яваад байгаа юм.

Хувьцаа эзэмшигч: Бордооны үйлдвэрлэлийн үйл ажиллагааг өргөжүүлэх хэрэгтэй байна. Энэ тал дээр ямар бодолтой байна? Тахианы махны чиглэлийн үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх үү?

ТУЗ-ийн дарга Л.Эрхэмбаяр: Манайхан хөрсөө бордохгүй бол болохгүйг одоо л ойлгох шинжтэй болж байна. Бордооны үйлдвэрээ яаж өргөжүүлэх үү гэдэг дээр судалгааны түвшинд явж байна. Маш сайн үндэсний бордоо бий болгоно. “Түмэн шувуут-1” үйлдвэр дээрх шиг Японы тоног төхөөрөмж оруулж ирвэл 2 тэрбум төгрөг орно. Тийм юм хийхгүй байгалиар нь хийхийг бодож байна. Тахианы махны чиглэлээр бидэнд боломж байгаа.

Хувьцаа эзэмшигч: Хувьцааны үнэ өсөх боломжтой юу?

ТУЗ-ийн дарга Л.Эрхэмбаяр: Хэдэн жилийн өмнө 800 хүрсэнийг санаж байна уу та нар. Бид сайн л ажиллах ёстой.

Хувьцаа эзэмшигч: Инфляци өндөр байгаа. Өндөгний үнийг 500 төгрөгт бариад удаж байна. Хэзээ нэгэн цагт өндөгний үнийг нэмэх шаардлага үүсэх байх. Хувьцаа эзэмшигчийн хувьд өндөгний үнийг нэмэгдээсэй гэж хүсч байна. Жилийн өмнө ТУЗ-ийн гишүүд 1 тэрбум төгрөгөөр хувьцаа халааслана гэж ярьсан. Жилийн эцсийн тайлангаас харахад 180 сая төгрөгөөр хувьцаа халаасалсан байсан. “Түмэн шувуут-3” төсөл дээр нилээн зардал гарсан байх. Энэ жил дахиад 500 сая төгрөгөөр хувьцаагаа халаасална гэж байсан. Энд хариулт өгнө үү?

ТУЗ-ийн дарга Л.Эрхэмбаяр: Би бас өндөгний үнэ нэмэгдээсэй гэж бодож байна. Гэхдээ зах зээлд өрсөлдөөн бол хатуу байдаг. Ойрын үед өндөгний зах зээл ханасан. 300 мянган шувууны аж ахуй, Эрдэнэт 20,000 гээд ханасан байгаа. Одоо дотооддоо өрсөлдөж байна. 6-7 сард өндөгийг хориулмаар байна. Стандарт агуулахтай байх ёстой. Зуны улиралд хордлого их байлаг. Оросоос өндөг маш их орж ирдэг. Энэ бол биологийн үйлдвэрлэл юм. 6-7 сард хүүхдүүд сургууль цэцэрлэг амардаг, баяр наадам болдог энэ хугацаанд Орос өндөгийг болиулаад өгөөч гээд байнга ХААХЯ энэ тэрээс гуйдаг. Ийм учраас өндөгний үнийг нэмэх маш хүнд асуудал юм. Өндөгний үнийг буулгах шиг амархан юм байхгүй. Өсгөх мах хэцүү.

ТУЗ-ийн гишүүн Г.Мөнх-Эрдэнэ: Өнгөрсөн жил бүтээн байгуулалт хийнэ гэдгээ төлөвлөсөн байсан учраас хатуу дүн хэлэхээс илүү хүртэлх гэдэг байдлаар явсан. Та бас түрүүн хэлж байсан. Шууд 1 тэрбум гэсэн бол бид 820 саяд бүтээн байгуулалтаа хийж чадахгүйд хүрэх байсан. Хувьцаагаа аваад тэр мөнгөө банкнаас зээлэх үү, эсвэл хувьцаа авахаа багасгаад тэр мөнгөөрөө бүтээн байгуулалтын ажлаа дуусгаад үйлдвэрлэлээ 1 сарын наана ч гэсэн ашиглалтанд оруулах уу гэдэг 2 зүйлийн сонголтон дээр явсан. Энэ жилийн хувьд бүтээн байгуулалт нилээн шувтарч байгаа учраас мөнгөн хөрөнгийн боломж илүү гарч ирж байгаа учраас яг 500 саяд худалдаж авна гэж оруулсан. Яг хэзээ

авахын гэдэг дээр ТУЗ-ийн шийдвэр гарсан. Бид бөөнд нь авч ханш өсгөх сонин биш. Ханш бодитой, тогтвортой л өсч байх ёстой. Тодорхой давтамжтайгаар хугацаандаа цувуулаад тогтсол худалдан авалт хийх зарчмыг баримталж явна.

ТУЗ-ийн дарга Л.Эрхэмбаяр: Анх хувьцаа өсөхгүй байна гээд байдаг байсан одоо биднээс шалтгаалахгүй байгааг их ойлгодог болсон байна. Олон хүчин зүйлээс болоод хувьцааны ханш өсөхгүй байна.

Үүгээр асуулт хариултын хэсэг өндөрлөв.

Тооллогын комиссын дүнг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах шийдвэрийг ТУЗ-ийн дарга Л.Эрхэмбаяр хувьцаа эзэмшигчдэд уншиж танилцууллаа. Хурлын дарга Л.Эрхэмбаяр Хуралд оролцогсдод талархал илэрхийлснээр 17:55 цагт хурал өндөрлөв.

ТАНИЛЦСАН ХУРЛЫН ДАРГА:  Л.ЭРХЭМБАЯР

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:  Д.НАРАНЦЭЦЭГ

